

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 12 сарын 27-ны өдөр

№ 491/Т/472

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.9.1, 31.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын дэвтрийн үлгэрчилсэн загвар”-ыг хоёрдугаар, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт төгсөгчдөл олгох мэргэшлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний загвар”-ыг гуравдугаар, “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ыг дөрөвдүгээр, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн үнэмлэхний загвар”-ыг тавдугаар, “Мэргэшлийн зэрэг горилогчийн өргөдлийн маяг”-ыг зургаадугаар, “Мэргэшлийн зэрэг олгох комиссын дүнгийн хуудас”-ыг дооодугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтүяа), Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ш.Булга-Эрдэнэ) нарт, хэрэгжилтийг зохион байгуулах, төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

3. Шинэчлэгдэн батлагдсан журамд нийцүүлэн “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтыг төрөөс санхүүжүүлэх журам”-ыг 2014 оны 2-р улиралд багтаан шинэчлэн боловсруулж батлуулахыг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагааны чиг үүрэгт холбогдох асуудлыг тусгах, сургалтын хичээлийн хөтөлбөр, үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинэчлэн хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 408/500 тоот хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт (цаашид “төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт” гэх) эрхлэх, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд суралцах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино;
- 1.2 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтыг төрөөс санхүүжүүлэх асуудлыг Эрүүл мэнд, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулна;
- 1.3 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын чиглэл, индексийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батална;
- 1.4 Эрүүл мэндийн тухай хуульд заасан орон тооны бус зөвлөл (“Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл” –цаашид зөвлөл гэх) нь төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, төгсөлтийн дараах сургалтанд суралцах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ;
- 1.5 Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулна.
- 1.6 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгоотой өдөр тутмын үйл ажиллагааг Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтэс (цаашид “ажлын алба” гэх) гүйцэтгэнэ;

Хоёр. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын хэлбэр, агуулгын багтаамж, хугацаа, элсэлт, төгсөлт

- 2.1 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтыг мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт гэсэн үндсэн хэлбэрээр зохион байгуулна;
- 2.2 Мэргэшүүлэх сургалт нь үндсэн мэргэшлийн, төрөлжсөн мэргэшлийн гэсэн 2 төрлийн мэргэжил олгох сургалттай байна;
- 2.3 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын багтаамжийг багц цагаар хэмжинэ;
- 2.4 Үндсэн мэргэшлийн сургалтын элсэлтийн хяналтын тоог сургалт эрхлэх байгууллагын хүчин чадал, салбарын хүний нөөцийн хэрэгцээ, эрүүл мэндийн байгууллагын захиалгыг үндэслэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно;
- 2.5 Хүний их эмчийн үндсэн мэргэшлийн сургалт нь 132 багц цагаас доошгүй агуулгатай, 4 жилээс доошгүй үргэлжлэнэ. Харин Нүүр амын их эмч, Уламжлалт анагаахын их эмчийн үндсэн мэргэшлийн сургалт нь 2 жил буюу 88 багц цагаас

доошгүй байна. Үндсэн мэргэшлийн сургалт дүүргэснийг гэрчилэх баримт бичиг нь мэргэшлийн диплом байна;

2.6 Хүний их эмч нь үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдахад өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд ажилласан 2 жилийг шалгуур хангасан тохиолдолд 2 жилд 44 багц цаг биелүүлсэн гэж үзэж үндсэн мэргэшлийн сургалтыг үргэлжлүүлэн тооцно;

2.7 Үндсэн мэргэшлийн сургалтанд эрүүл мэндийн байгууллагын захиалгаар суралцагсад суралцана. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хяналтын тоо нь эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн үндсэн мэргэшлээр суралцагсдын захиалгын тооноос илүү гарсан тохиолдолд үлдсэн хяналтын тоонд багтаан хувийн зардлаар суралцагчид элсэлтийн шалгалтанд тэнцсэн үед элсүүлнэ;

2.8 Эрүүл мэндийн захиалагч байгууллага нь суралцагчтай гэрээ хийж, суралцах хугацаанд цалинжуулах, төгссөний дараа ажлын байраар хангах үргийг хүлээнэ;

2.9 Хүний их эмч, Эм зүйч, Уламжлалт анагаахын их эмч, Нүүр амны эмч, Биоанагаахын мэргэжилтэн, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний төрөлжсөн мэргэшлийн сургалт нь сард 4 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай, 6 сар ба түүнээс дээш хугацаатай үргэлжлэх ба гэрчилэх баримт бичиг нь мэргэшлийн үнэмлэх байна;

2.10 Сувилагч, Эм найруулагч, Эх баригч болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад мэргэжилтний мэргэшүүлэх сургалт нь сард 4 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай, 6 сар хүртэлх хугацаатай үргэлжилнэ;

2.11 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын тасралтгүй сургалт нь мэргэжлийн чиглэлээр нэмэлт мэдлэг, ур чадварыг олгоход чиглэх ба мэргэжил дээшлүүлэх болон багц цагийн сургалт гэсэн 2 хэлбэрээр явагдана;

2.12 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалт сард 4 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай, 6 сар хүртэлх хугацаагаар үргэлжлэх ба гэрчилэх баримт бичиг нь гэрчилгээ байна;

2.13 Багц цагийн сургалт нь эмнэлгийн мэргэжилтэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд бүрдүүлэх ёстой багц цагийг биелүүлэхэд чиглэсэн сэдэвчилсэн, ажлын байран дээрхи болон зайны сургалт хэлбэрээр явагдах ба гэрчилэх баримт бичиг нь багц цагийн тэмдэглэгээ бүхий гэрчилгээ байна;

2.14 Ажлын алба нь мэргэшүүлэх сургалтанд элсэгчдийг уралдаант шалгалтаар шалгаруулан, хяналтын тоог үндэслэн нэгдсэн зохион байгуулалтаар сургалт эрхлэх байгууллагуудад хуваарилах;

2.15 Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн төгсөлтийн улсын шалгалтын комиссыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилж, сургалт дууссанаас хойш 14 хоногт багтаан ажлын алба нэгдсэн журмаар зохион байгуулна;

2.16 Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалт төгсөгчдийн нэrsийн жагсаалт, мэргэшлийн дипломын дугаарыг болон мэргэшлийн үнэмлэхийн серийн дугаарыг төгсөлтийн шалгалтын комиссын хурлын тэмдэглэлийг үндэслэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна;

2.17 Тасралтгүй сургалт зохион байгуулах эрх авсан байгууллага нь төгсөгчдийн нэrsийн жагсаалт, гэрчилгээний серийн дугаарыг ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр баталгаажуулна;

2.18 Тасралтгүй сургалт нь 10-аас доош хоногоор зохион байгууллагдах тохиолдолд сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүй, ноогдох багц цагийг ажлын

алба хянаж, зөвшөөрөл олгон, сургалтанд оролцогсдын нэрс, гэрчилгээний серийн дугаарыг баталгаажуулах ба гэрчилгээнд сургалт зохион байгуулсан байгууллагын дарга/захирал гарын үсэг зурж, байгууллагын тамга дарна;

Гурав. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын удирдлага, зохион байгуулалт

3.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах;

3.1.2. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын бодлого, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх санал боловсруулж, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;

3.1.3. Боловсролын болон эрүүл мэндийн тусгай хууль эрх зүйн орчинд нийцүүлэн Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын холбогдох журам, зөвлөмж, аргачлал боловсруулан батлуулах;

3.1.4. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын асуудлаар ажлын алба болон сургалт эхлэх байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хэрэгцээ, төлөвлөтөнд үндэслэн төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллагын чадавхийг харгалзан, эрүүл мэндийн байгууллагуудын захиалгын дагуу төрийн сангаар санхүүжих сургалтын чиглэл, элсэгчдийн хяналтын тоог тогтоох;

3.1.6 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын элсэлт, төгсөлтийн улсын шалгалт (цаашид “шалгалт” гэх)-ын журмыг боловсруулах;

3.2 ЭМХТ нь төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1 Эмнэлгийн мэргэжлийн хөгжлийн Зөвлөлийн ажлын албаны үүрэг гүйцэтгэх;

3.2.2 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг дагалдах дүрэм, журам, удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.3 Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтанд элсэгч, төгсөгчдөөс авах улсын нэгдсэн шалгалтыг зохион байгуулах, сургалт дүүргэснийг гэрчилэх мэргэшлийн диплом, үнэмлэх, гэрчилгээг эрх бүхий албан тушаалтанаар баталгаажуулан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.2.4 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллага болон элсэгч, суралцагч, төгсөгчидтэй холбоотой цахим мэдээний санг тогтмол ажиллуулах, боловсронгуй болгох, хяналт тавих;

3.2.5 Мэдээний сан болон эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх санал боловсруулах;

3.2.6 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын талаарх дүн шинжилгээ бүхий тайланг бичгээр болон цахим хэлбэрээр жил бурийн 12 дугаар сарын 25-ны дотор авч ЭМЯ-ны холбогдох хэлтэст ирүүлэх;

3.2.7 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Зөвлөлд тайлагнах;

3.2.8 Сургалт эрхлэх байгууллагатай гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.9 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллага болон суралцагчаас гаргасан санал, хүсэлтийг хянан шийдвэрлэх;

3.2.10 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалттай холбоотой мэдээллийг www.chd.moh.mn цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод мэдээлэх;

3.2.11 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвөөс Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу 5 жил тутамд мэргэжилтнээ төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд хамруулах төлөвлөгөө, жил бүрийн сургалтын хэрэгцээний саналыг авах;

3.2.12 Сургалтын цөм хөтөлбөрийг шинээр боловсруулах, үнэлэх, шинэчлэх ажлыг тухай бүр зохион байгуулах;

3.2.13 Зөвлөлөөс баталсан тэргүүлэх чиглэлийн дагуу зохион байгуулах сургалтанд хяналт тавьж, тайланг Зөвлөлөөр хэлэлцүүлэх;

3.2.14 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт удирдах боловсон хүчнийг сурган заах арга зүйн хувьд чадавхижуулах сургалтыг байнга зохион байгуулах;

3.2.15 Эрүүл мэндийн захиалагч байгууллага нь үндсэн мэргэшлийн суралцагчийн цалинг тухайн жилийн төсөвтөө суулган батлуулах, хуваарилахад хяналт тавих;

3.2.16 Үндсэн мэргэшлийн суралцагч болон өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд ажиллаж буй 2 жилийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмчийн цалин, хөлс олголтонд тогтмол хяналт тавьж зохион байгуулах;

3.2.17 Суралцагч үндсэн мэргэшлийн сургалтыг төгсөөд гэрээний дагуу тухайн захиалагч эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

3.3 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтыг дараах хугацаанд зохион байгуулна:

3.3.1 Үндсэн болон төрөлжсэн мэргэшлийн сургалт нь жил бүрийн 10 дугаар сарын 1-нд, дээшлүүлэх сургалт нь жил бүрийн 10 дугаар сарын 1-нд, 3 дугаар сарын 1-нд, багц цагийн сургалт нь жилийн туршид зохион байгуулагдана;

3.3.2 Үндсэн болон төрөлжсэн мэргэшлийн сургалтанд элсэгчдийг жил бүрийн 9 дүгээр сарын 5-аас 9 дүгээр сарын 20-ны дотор, дээшлүүлэх сургалтанд элсэгчдийг жил бүрийн 9 дүгээр сарын 5-аас 9 дүгээр сарын 20-ны дотор; 2 дугаар сарын 5-аас 20-ны хооронд тус тус бүртгэж, элсэлтийн шалгалтыг 9 дүгээр сарын 25 ба 2 дугаар сарын 25-ны дотор тус тус зохион байгуулна;

Дөрөв. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх, зохион байгуулах байгууллагад тавигдах нийтлэг шаардлага

4.1 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг Зөвлөлөөс эрх авсан анааах ухааны боловсрол олгох сургууль, эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллага эрхлэх буюу зохион байгуулна;

4.2 Зөвлөл нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байгууллагад төгсөлтийн дараах мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгоно. Үүнд:

4.2.1 Мэргэшлийн чиглэл тус бүрээр батлагдсан сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;

4.2.2 Батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгжтэй байх;

4.2.3 Сургалтын үйл ажиллагаа явуулах журамтай байх;

4.2.4 Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүнтэй байна. Багшлах бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх;

4.2.5 Мэргэшүүлэх сургалтанд удирдагч багш 2-оос илүүгүй суралцагч дагалдуулах, бага бүлгээр хичээллэх суралцагчдын тоо 8-аас илүүгүй байхаар зохион байгуулсан байх;

4.2.6 Багшлах бүрэлдэхүүнийг сурган заах арга зүйн сургалтанд хамруулж, ур чадварыг дээшлүүлэх төлөвлөгөөтэй байх;

4.2.7 Мэргэжлийн онцлогт тохирсон сургалтын танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, лаборатори бүхий сургалтын түшиц эмнэлэгтэй байх;

4.2.8 Сургалтын орчин бүрдүүлсэн байх (байнгын үйл ажиллагаатай хэвлэх, хувилах төхөөрөмж, интернет бүхий компьютер, мэргэжлийн номын сан, амрах, хувцас солих өрөө г.м.);

4.2.9 Энэхүү журмын 4.2.7-д заасан түшиц эмнэлэг байхгүй эсхүл 4.2.8-д заасан сургалтын орчин байхгүй тохиолдолд сургалтын онцлогт тохирохуйц эмнэлэг буюу анагаах ухааны боловсрол олгох сургалтын байгууллагатай гэрээ байгуулсан байх (Гэрээнд урсгал болон бусад зардалтай холбоотой төлбөрийг тусгасан байна);

4.3 Зөвлөл нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байгууллагад тасралтгүй сургалтыг зохион байгуулах эрх олгоно. Үнд:

4.3.1 Мэргэжил дээшлүүлэх сургалт нь нэг сараас дээш хугацаатай бол цөм хөтөлбөрийг Зөвлөлөөр батлуулсан байх, 1 сараас доош хугацаатай бол хөтөлбөрийг сургалт эрхлэх эрх бүхий сургалтын байгууллагаар батлуулсан байх;

4.3.2 Улсын бүртгэлийн гэрчилгээ, албан ёсны нэр, тэмдэг, хэвлэмэл хуудастай байх;

4.3.3 Тухайн сургалтын агуулгад тохирсон техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх;

4.3.4 Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүнтэй байна;

Тав. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт удирдах багшид тавигдах нийтлэг шаардлага

5.1 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт удирдах багшид дараах шаардлага тавигдана. Үнд:

5.1.1 Тухайн мэргэжлээрээ магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй буюу тэргүүлэх ба түүнээс дээш мэргэшлийн зэрэгтэй байх;

5.1.2 Тухайн мэргэжлээрээ 5 буюу түүнээс дээш жил ажилласан буюу мэргэжлийн сургалт зохион байгуулсан туршлагатай байх;

5.1.3 Эмнэл зүйн сургалт удирдах тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

5.1.4 Сурган заах арга зүйн сургалтанд хамрагдсан үнэмлэх, гэрчилгээтэй байх;

5.1.5 Тухайн байгууллагын үндсэн ажилтан биш бол сургалт эрхлэх байгууллагатай гэрээ байгуулсан байх;

Зургаа. Суралцагчдад тавигдах нийтлэг шаардлага

- 6.1 Үндсэн мэргэшлийн сургалтанд элсэх их эмчид дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
- 6.1.1. Анагаах ухаан, уламжлалт анагаах ухаан, нүүр амны чиглэлээр бакалаврын дипломтой байх;
 - 6.1.2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх 5 жилийн зөвшөөрөлтэй байх;
 - 6.1.3. Эрүүл мэндийн бусад чиглэлээр мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтанд давхар элсээгүй байх;
 - 6.1.4. Захиалагч эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;
 - 6.1.5. Анагаах ухааны бакалаврын сургалтын нийт багц цаг нь элсэх гэж буй сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, багтаамжийг хангасан байх;
 - 6.1.6. Элсэлтийн шалгалтад тэнцсэн байх;
 - 6.1.7. Бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулгын багтаамж нь тухайн үндсэн мэргэшлийн сургалтын шаардлагыг хангахгүй тохиолдолд уг хичээлийг багц цагаар тооцон нөхүүлсэн байх;
- 6.2 Төрөлжсэн мэргэшлийн сургалтанд элсэх их эмчид дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
- 6.2.1 Үндсэн мэргэжлийн болон мэргэшлийн дипломтой байх;
 - 6.2.2 Үндсэн мэргэшлийн сургалтаар эзэмшсэн мэргэжлээрээ 1 буюу түүнээс дээш жил ажилласан байх;
 - 6.2.3 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
 - 6.2.4 Эрүүл мэндийн бусад чиглэлээр мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтанд давхар элсээгүй байх;
 - 6.2.5 Элсэлтийн шалгалтанд тэнцсэн байх;
- 6.3 Мэргэшүүлэх сургалтанд элсэх сувилагч, эм найруулагч, эх баригч болон анагаах ухааны боловсрол олгох коллеж төгссөн эмнэлгийн бусад мэргэжилтэнд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
- 6.3.1 Төгсөлтийн өмнөх сургалтын диплом, түүнтэй адилтгах баримт бичигтэй байх;
 - 6.3.2 Эрүүл мэндийн бусад чиглэлээр мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтанд давхар элсээгүй байх;
 - 6.3.3 Мэргэжлээрээ 1 буюу түүнээс дээш жил ажилласан байх;
 - 6.3.4 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
 - 6.3.5 Элсэлтийн шалгалтад тэнцсэн байх;
- 6.4 Мэргэжил дээшлүүлэх сургалтанд элсэгчдэд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:
- 6.4.1 Тухайн мэргэжлийн диплом, мэргэшлийн диплом, үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичигтэй байх;
 - 6.4.2 Мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдснаас хойш 2 ба түүнээс дээш жил ажилласан байх;
 - 6.4.3 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

Долоо. Сургалтын цөм хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага

- 7.1 Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын цөм хөтөлбөр дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 7.1.1 Сургалтын цөм хөтөлбөрийн агуулга нь сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаа, мэргэжлийн үндсэн чиг үүрэгт нийцсэн байх;
- 7.1.2 Мэргэшүүлэх сургалтын нийт багц цагийн 20-25 хувь нь онолын, 75-80 хувь нь дадлагажих сургалт байх;
- 7.1.3 Сургалтын цөм хөтөлбөрийн агуулга нь төгсөлтийн өмнөх сургалттай залгамж холбоотой, үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр мэргэшүүлэх чиглэлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг бүрэн төлөвшүүлэхэд чиглэсэн байх;
- 7.1.4 Сургалтын цөм хөтөлбөрт тухайн сургалтын зорилго, зорилт, сургалтын үргэлжлэх хугацаа, сургалтын агуулга, стандарт, сургалтын хэлбэр, үнэлгээ, эзэмшвэл зохих гардан үйлдлийн тоо, мэдээллийн эх сурвалж, хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага болон сүүлийн үед нэвтэрч буй эмчилгээ, оношлогоо, сувилгааны шинэ арга аргачлал, шинэ эм, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, тэдгээрийн хэрэглээг тусгах;

Найм. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материал

- 8.1. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллага нь зөвшөөрөл хүсэхэд дараах материалыг бүрдүүлэн ажлын албанад ирүүлнэ. Үүнд:
- 8.1.1 Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- 8.1.2 Мэргэжлийн сургалтын чиглэл, тухайн сургалтыг явуулах үндэслэл, хэрэгцээ шаардлага, гарах үр дүн, сургалтын төрөл, хэлбэрийг тодорхой тайлбарласан албан бичиг;
- 8.1.3 Байгууллагын товч танилцуулга, төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг хангасныг батлах баримтын хуулбар (тусгай зөвшөөрөл г.м.);
- 8.1.4 Сургалтын агуулгад тохирсон сургалтын байр, техник хэрэгсэл, ном сурах бичиг зэрэг сургалтын үндсэн хэрэглэгдэхүүний жагсаалт (фото зураг);
- 8.1.5 Энэхүү журмын 4.2.7-д заасан түшиц эмнэлэг байхгүй эсхүл 4.2.8-д заасан сургалтын орчин байхгүй тохиолдолд эмнэлэг буюу анагаах ухааны боловсрол олгох сургуультай байгуулсан гэрээ (эх хувь);
- 8.1.6 Байгууллагын дотоод журам, сургалтын үйл ажиллагаа явуулах журмуудын хуулбар, багшлах бүрэлдэхүүн, чадавхийн тодорхойлолт (оловсрол, боловсролын болон мэргэшлийн зэргийн бичиг баримтын баталгаажуулсан хуулбар);
- 8.1.7 Зөвлөлөөр батлагдсан сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөө;

Ес. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох

- 9.1 Ажлын алба сургалт эрхлэхээр шинээр хүсэлт гаргасан байгууллагын материалыг хянах болон тухайн байгууллага дээр очиж танилцсаны дараа Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, сургалт эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг Зөвлөлийн даргаар баталгаажуулсан олгоно.
- 9.2 Харин давтан хүсэлт гаргасан байгууллагын үйл ажиллагааны тайлан, явцын хяналт, үнэлгээг Зөвлөлөөр хэлэлцүүлэн сургалт эрхлэх эрхийг сунгана.
- 9.3 Төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрлийг доор дурдсан хугацаагаар сунгах буюу олгоно:
- 9.3.1 Үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагад 4 хүртэл жил;

- 9.3.2 Төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагад 2 хүртэл жил;
 9.3.3 Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагад 2 хүртэл жил;

9.4 Дараах тохиолдолд сургалт эрхлэх байгууллагын төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвлөлөөр хэлэлцэж хүчингүй болгоно. Үүнд:

9.4.1 Сургалтыг товлосон хугацаанаас хойш 1 сараас илүү хугацаанд эхлүүлээгүй, сургалтын явцад үйл ажиллагаагаа хүндэтгэх шалтгаангүйгээр зогсоосон;

9.4.2 Явцын үнэлгээнд хангалтгүй дүн үзүүлсэн;

9.4.3 Сургалтын орчин нь шаардлага хангахгүй, сургалтын цөм хөтөлбөр төлөвлөгөөний стандартыг зөрчсөн, суралцагчдын санал, гомдол, мэдээлэлд дурдсан зөрчил нь шалгалтаар тогтоогдсон;

9.4.4 Байгууллага нь татан буугдсан буюу өөрчлөгдсөн;

9.4.5 Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний заалт зөрчигдсөн;

9.4.6 Зөвлөлөөс өгсөн зөвлөмж, үүрэг даалгаварыг биелүүлээгүй тохиолдолд;

Арав. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын хяналт- шинжилгээ, үнэлгээ

10.1 Ажлын албанаас үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагуудын үйл ажиллагааны үнэлгээний тайланг жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор, төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор авч, зөвлөлд ирүүлнэ;

10.2 Явцын хяналт-шинжилгээг тухайн сургалтын хугацаанд ажлын алба, үнэлгээг сургалт эрхлэх байгууллагын сургалт эрхлэх зөвлөөрлийн хугацаанд Эрүүл мэндийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь бусад холбогдох талуудыг оролцуулан тус тус хийнэ;

10.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Зөвлөлөөр хэлэлцүүлэн сургалт эрхлэх эрхийг үргэлжлүүлэн сунгах эсэхэд харгалзана;

Арван нэг. Сургалт эрхлэх байгууллагын эрх, үүрэг.

11.1 Сургалт эрхлэх байгууллага дараах эрхтэй:

11.1.1 Суралцагч хүндэтгэх шалтгаанаар хөтөлбөрөө бүрэн гүйцэтгээгүй тохиолдолд тухайн багц цагт тооцсон нэмэлт төлбөр авч сургалтыг нөхүүлэх;

11.1.2 Суралцагч хүндэтгэх шалтгаангүй 1 сар ба түүнээс дээш хугацаагаар сургалтаас завсардсан, тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд сургалтаас хасах;

11.2 Сургалт эрхлэх байгууллага дараах үүргийг хүлээнэ:

11.2.1 Суралцагчдад суралцах үйл явцтай нь шууд холбоогүй үүрэг даалгавар өгөхгүй байх;

11.2.2 Нийтийг хамарсан гамшигийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал болон гамшигийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр суралцагчийг дайчлан ажиллуулах;

11.2.3 Сургалтын үйл ажиллагааг дэмжсэн орчин, нөхцлийг бүрдүүлэх, байнга шинэчлэн сайжруулах;

11.2.4 Сургалтын үйл явцыг үнэлэх, дотоод хяналт тавих, эргэн мэдээлэх тогтолцоотой байх;

11.2.5 Батлагдсан загварын дагуу суралтын дэвтэртэй байх;

11.2.6 Суралцагчийг ажиллуулахтай холбоотой үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулсан заалтыг байгууллагын дотоод журамд тусгах;

11.2.7 Сургалтын төрөл, хэлбэрийг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай бол түүний үндэслэл, хэрэгцээ, дэвшилттэй тал, ач холбогдлыг тодорхой тусгасан нэмэлт бичиг баримтыг бүрдүүлэн сургалт эхлэхээс 3 сарын өмнө ажлын албанд ирүүлэх;

11.2.8 Сургалтын төлбөрийг зориулалтын дагуу зарцуулах;

11.2.9 Сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж, жил бүрын 06 дугаар сарын 25-ны дотор ажлын албанд ирүүлэх, тайлангуудыг ажлын алба нэгтгэн Зөвлөлд дараа оны 1-р сарын 20-ны дотор танилцуулах;

Арван хоёр. Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын суралцагчийн төлбөр, цалин олголт

12.1 Үндсэн мэргэшлийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх ба төрөөс санхүүжүүлэх төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын төлбөр, холбогдох зардлын жишгийг Эрүүл мэнд, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулна.

12.2 Эрүүл мэндийн байгууллага нь 1 жилийн өмнө үндсэн мэргэшлийн суралцагчдийн захиалгийг өгч, жил бүрийн төсөвтөө тусгана.

12.3 Сургалт эрхлэх байгууллага нь шинээр суралцуулах боломжтой элсэгчдийн тоо болон үргэлжлүүлэн суралцаж буй суралцагчдын тоог ЭМХТ-д мэдээлнэ.

12.4 Ажлын алба нь захиалагч болон сургалт эрхлэх байгууллагаас ирсэн тоог нэгтгэн ЭМЯ-д хүргүүлэн, сайдын тушаалаар элсэгчдийн хяналтын тоог баталгаажуулна.

12.5 Үндсэн мэргэжлээр суралцагчийн цалинг захиалгаар суралцуулж буй эрүүл мэндийн байгуулага жил бүрийн төсөвтөө багтаан суралцах хугацаанд нь цалинжуулна.

---000---

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх
ухааны сайдын 2013 оны 27. сарын 27.-ны
өдрийн 191 тоот хамтарсан
тушаалын хөөрбугаар хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн
дараах мэргэжлийн сургалтын дэвтрийн үлгэрчилсэн загвар

№

Эцэг/эхийн нэр..... Нэр

Нас

Хүйс эрэгтэй/эмэгтэй (зурна уу)

Үндсэн байгууллага

мэргэжлээр үндсэн мэргэшлийн /төрөлжсөн мэргэшлийн /дээшлүүлэх (зурна уу)
сургалтанд оны сарын өдөр элсүүлэв.

Суралцах хугацаа жил сар

Олгосон оны сарын өдөр

ЗАХИРАЛ

1-р ДАМЖАА оны улирал

Суралцагчийн нэр Сургалтын дэвтрийн дугаар

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

УЛИРЛЫН ШАЛГАЛТ

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

2-р ДАМЖАА оны улирал

Суралцагчийн нэр Сургалтын дэвтрийн дугаар

22

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

УЛИРЛЫН ШАЛГАЛТ

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

3-р ДАМЖАА

..... оны улирал

Суралцагчийн нэр

Сургалтын дэвтрийн дугаар

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

УЛИРЛЫН ШАЛГАЛТ

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

4-р ДАМЖАА

..... оны улирал

Суралцагчийн нэр

Сургалтын дэвтрийн дугаар

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

УЛИРЛЫН ШАЛГАЛТ

№	Хичээл	Багц цаг		Үнэлгээ	Дүн	Сар өдөр	Гарын үсэг
		авах	авсан				

Суралцагчийн нэр

Сургалтын дэвтрийн дугаар

ДАХИН ӨГСӨН УЛИРЛЫН ШАЛГАЛТ

№	Хичээлийн нэр	Сар өдөр	Үнэлгээ	Дүн	Гарын үсэг

Суралцагчийн нэр

Сургалтын дэвтрийн дугаар

Явцын дүн

№	Үзүүлэлт	Дүн /хувиар %/				Ерөнхи й дүн
		I улирал	II улирал	III улирал	IV улирал	
1.	Лекцийн ирц					
2.	Дадлагын ирц					
3.	Семинар					
4.	Клиникийн ярилцлагын шалгалт					
5.	Тестийн шалгалт					
6.	Жижуурийн тайлан					
7.	Гардан үйлдлийн шалгалт					
8.	Ёс зүй, хандлага харилцаа					
Голч дүн						

Суралцагчийн нэр

Сургалтын дэвтрийн дугаар

ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ

№	Хичээлийн нэр	Сар өдөр	Үнэлгээ	Дүн	Гарын үсэг
1.					
2.					
3.					

Ерөнхий дүн

Голч дүн

Шалгалтын комисс:

Дарга
Гишүүд:

Зөвшөөрсөн суралцагчийн гарын үсэг

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх
ухааны сайдын 2013 оны 12 сарын 27-ны
өдрийн 12 тоот хамтарсан тушаалын
буравдугаар хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах
мэргэжлийн сургалт төгсөгчдөд олгох мэргэшлийн диплом,
мэргэшлийн үнэмлэх, гэрчилгээний загвар

**Загвар 1. Үндсэн мэргэшлийн сургалт төгсөгчдөд олгох
мэргэшлийн диплом**

1. Үндсэн мэргэшлийн сургалт төгсөгчдөд олгох диплом нь хатуу хавтастай, хавтасны нүүрний доод хэсэгт "ДИПЛОМ" гэж бичсэн байна.
2. Дипломын дотор тал цайвар шар өнгийн дэвсгэртэй, гадуураа шаргал өнгийн алхан хээтэй байна.
3. Диплом нь 105 мм x 148,5 мм хэмжээтэй хоёр хуудсан дээр монгол, англи хэлээр бичигдсэн байна
4. Дипломын баруун дээд буланд Эрүүл мэндийн яамны бэлгэдэл, зүүн дээд буланд сургалт эрхлэх байгууллагын бэлгэдлийг тус тус байрлуулж, түүний доор "ДИПЛОМ" гэж бичиж дугаар бичих зاي үлдээсэн байна.
5. Дипломд төгсөгчийн овог нэр, суралцсан байгууллагын нэр, мэргэшсэн мэргэшлийн нэр, мэргэжил олгосон үндэслэлийг бичиж, дараах албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Үүнд:
 - Зөвлөлийн дарга
 - Улсын шалгалтын комиссын дарга
 - Тухайн сургалт эрхэлсэн байгууллагын дарга/захирал

Төгсгөлд нь олгосон он, сар, өдөр, газрын нэрийг бичнэ.

Загварыг хавсаргав.

ЗАГВАР 1

ДИПЛОМ

№

..... овогтой НЬ
 -ЫН МЭРГЭШЛЭЭР ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БҮРЭН ДУУРГЭСЭН ТУЛ ЭРҮҮЛ
 МЭНДИЙН САЙДЫН ОНЫ ДУГААР ТООТ ТУШААЛЫГ ҮНДЭСЛЭН
 МЭРГЭЖИЛ ОЛГОВ.

Кредит цаг

.....
 Зөвлөлийн дарга Улсын шалгалтын комиссын
 дарга

.....
 Сургалт эрхлэгч байгууллагын
 дарга/захирал

Тамга

Тамга

ОГНОО

ОЛГОСОН ГАЗАР

Draft 1

Logo
Ministry of Health

Logo

DIPLOMA

Nº

This diploma is awarded to.....
In recognition of your completion of specialist training at
the.....in specialization as
.....
by the decrees of the Minister of Health,
Completed credits.....
.....
Head of the committee
of the State examination

Rector/ Director
Chairman of the committee
of the State examination

Stamp

Stamp

Date...

Place....

27

Загвар 2. Төрөлжсөн мэргэшлийн сургалт төгсөгчдөд олгох мэргэшлийн үнэмлэх.

1. Төрөлжсөн мэргэшлийн сургалт төгсөгчдөд олгох Мэргэшлийн үнэмлэх нь хатуу хавтастай, хавтасны нүүрний доод хэсэгт "Мэргэшлийн үнэмлэх" гэж бичсэн байна.
2. Мэргэшлийн үнэмлэх нь цайвар шар өнгийн дэвсгэртэй гадуураа бор шаргал өнгийн алхан хээтэй байна.
3. Мэргэшлийн үнэмлэх нь 105 мм x 148,5 мм хэмжээтэй хоёр хуудсан дээр монгол, англи хэлээр бичигдсэн байна.
4. Мэргэшлийн үнэмлэхний баруун дээд буланд ЭМХТ-ийн бэлгэдэл, зүүн дээд буланд сургалт эрхлэгч байгууллагын бэлгэдлийг байрлуулж, түүний доор "Мэргэшлийн үнэмлэх" гэж бичиж, дугаар бичих зай үлдээсэн байна.
5. Мэргэшлийн үнэмлэх дээр төгсөгчийн овог нэр, суралцсан байгууллагын нэр, мэргэшсэн мэргэшлийн нэр, мэргэжил олгосон үндэслэлийг бичиж дараах албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Үүнд:

- Шалгалтын комиссын дарга
- Тухайн сургалт эрхэлсэн байгууллагын дарга/захирал

Төгсгөлд нь олгосон он, сар, өдөр, газрын нэрийг бичнэ.

/ Загварыг хавсаргав/

ЗАГВАР 2

Сургалт эрхлэх байгууллагын
бэлгэдэл

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
бэлгэдэл

МЭРГЭШЛИЙН ҮНЭМЛЭХ

Серийн дугаар

..... овогтой нь

..... мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн тул

ЭМХТ-ийн захирлын оны дугаар тушаалыг

үндэслэн мэргэжил олгов.

Кредит цаг

Шалгалтын комиссын
дарга

Сургалт эрхлэгч байгууллагын
захирал/ дарга

Огноо.....

олгосон газар.....

Draft 2

Logo

Logo

PROFESSIONAL
CERTIFICATE

No

This certificate is awarded to.....

In recognition of your completion of sub specialist training at
the.....

.....
in specialization as.....

by the decrees of the chairman of State implementing agency.....

Completed credits-.....

Presented by:

.....
Chairman of the general examination
committee

.....
Rector/ Director

Date...

Place.....

Загвар 3. Тасралтгүй сургалт төгсөгчдөд олгох гэрчилгээний загвар

1. Дээшлүүлэх болон багц цагийн сургалт төгсөгчдөд олгох гэрчилгээ нь 105 мм х 148,5 мм хэмжээтэй байна.
2. Гэрчилгээ нь цайвар шар өнгийн дэвсгэртэй гадуураа бор шаргал өнгийн алхан хээтэй байна.
3. Гэрчилгээний дээд гол хэсэгт сургалтын байгууллагын бэлгэдлийг байрлуулж түүний доор "Гэрчилгээ" гэж бичиж, дугаар бичих зاي үлдээсэн байна.
4. Гэрчилгээн дээр төгсөгчийн овог нэр, суралцсан мэргэшлийн нэр, мэргэжил олгосон үндэслэл, сургалтын хугацаа, кредит цагийг бичиж, сургалт эрхлэх байгууллагын дарга/захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Төгсгөлд нь олгосон он, сар, өдөр, газрын нэрийг бичнэ.

ЗАГВАР 3

Байгууллагын бэлэгдэл

Гэрчилгээ

Серийн дугаар

.....овогтой нь

мэргэжлээр давтан сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн тул
гэрчилгээ олгов.

Сургалтын хугацаа.....

Багц цаг.....

Дарга/захирал.....

Тамга

Огноо.....

олгосон газар.....

32

Draft 3

Logo

CERTIFICATE

Serial number

.....
For successful completion in field

.....
Duration.....

.....
Completed credits.....

Rector/ Director

.....
Date.....

.....
Place.....

---000---

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх
ухааны сайдын 2013 оны 12 сарын 27-ны
өдрийн 4910 тоот хамтарсан тушаалын
дерөвдүгээр хавсралт

Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг
олгох, хүчингүй болгох журам

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг “Эрүүл мэндийн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулахад оршино.

1.2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, үнэлэх, баталгаажуулахад чиглэгдэнэ.

1.3. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах бүтэц нь Эрүүл мэндийн тухай хуулийн 31.2-т заасан зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) байна.

1.4. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг Зөвлөлөөс мэргэшлийн зэрэг олгох шалгалт (цаашид “Зэргийн шалгалт” гэх) явуулах эрх авсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл (цаашид “Мэргэжлийн салбар зөвлөл” гэх) зохион байгуулна.

1.5. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалтын хэлтэс нь мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны ажлын алба(цаашид “ажлын алба” гэх)-ны үүргийг гүйцэтгэнэ.

1.6. Мэргэшлийн зэрэг нь ахлах, тэргүүлэх, зөвлөх гэсэн 3 шатлалтай бөгөөд зэргийг шатлал алгасуулан олгохгүй. Мэргэшлийн зэргийн хоорондох шатлал ахиулах хугацаа 5 ба түүнээс дээш жил байна.

1.7. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэргийг давхцуулан олгохгүй бөгөөд зөвхөн ажиллаж буй мэргэжлийн чиглэлээр зэрэг олгоно.

1.8. Хүний их эмч, эм зүйч, уламжлалт анагаах ухааны эмч, нүүр амны их эмч, сувилагч мэргэжлээр зөвлөх зэрэг олгоно.

1.9. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны зардлын жишигийг Эрүүл мэнд, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан тушаалаар зохицуулна.

2. Мэргэшлийн зэрэг олгох шалгуур

2.1. Ахлах зэрэг горилох шалгалт өгөх мэргэжилтэн нь дараах нийтлэг шалгуурыг хангана. Үүнд:

- 2.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх;
- 2.1.2. Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
- 2.1.3. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;
- 2.1.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;
- 2.2. Тэргүүлэх зэрэг горилох шалгалт өгөх мэргэжилтэн нь дараах нийтлэг шалгуурыг хангана. Үүнд:
- 2.2.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх;
- 2.2.2. Тухайн мэргэжлээрээ 13 түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх, одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй;
- 2.2.3. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;
- 2.3. Зөвлөх зэрэг горилох шалгалт өгөх мэргэжилтэн нь дараах нийтлэг шалгуурыг хангана. Үүнд:
- 2.3.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжлийн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх;
- 2.3.2. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх;
- 2.3.3. Боловсролын докторын зэрэгтэй байх;
- 2.3.4. Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй;
- 2.3.5. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;
- 2.4. Мэргэшлийн зэрэг горилох шалгалтанд ороход тавигдах тусгай шалгуур үзүүлэлтийг тухайн мэргэжлийн салбар зөвлөл мэргэжлийн онцлогийг харгалzan мэргэшлийн зэргийн шатлал тус бүрээр боловсруулж хэрэгжүүлэх ба нийтлэг шалгуурт байгаа үзүүлэлтийг тусгай шалгуурт давхцуулахгүй.
- 2.5. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь дараах шалгуурыг хангасан байна:
- 2.5.1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, албан ёсны нэр, тэмдэг, хэвлэмэл хуудастай байх;
- 2.5.2. Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх (татварын тайлангаар баталгаажуулна);
- 2.5.3. Байнгын орон тоо бүхий ажлын албатай байх;
- 2.5.4. Тухайн мэргэжлээр ажилладаг нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийн 30-аас доошгүй хувийг гишүүнчлэлдээ багтаасан байх;
- 2.5.5. Харьяалагдах эмнэлгийн мэргэжилтний дэлгэрэнгүй бүртгэл мэдээлэлтэй байх;
- 2.5.6. Холбогдох олон улсын мэргэжлийн нийгэмлэгийн гишүүн байх буюу тогтмол хамтын ажиллагаатай байх;
- 3. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаанд оролцох байгууллагуудын чиг үүрэг**
- 3.1. Ажлын албаны чиг үүрэг:
- 3.1.1. Зэргийн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтний (цаашид “зэрэг горилогч” гэх) нэрсийг ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр

- 35
- баталгаажуулан жил бүрийн 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны хооронд шалгалтыг зохион байгуулж, хяналт тавих;
- 3.1.2. Мэргэжлийн нийгэмлэг холбоо, мэргэжлийн салбар зөвлөл, хөндлөнгийн хяналтын төлөөллийг оруулсан зэргийн шалгалтын комисс томилох;
- 3.1.3. Жил бүрийн 11-р сард багтаан зэргийн шалгалт зохион байгуулах эрх хүссэн нийгэмлэг, холбооны хүсэлтийг Зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх;
- 3.1.4. Зэргийн шалгалт зохион байгуулах эрх авсан мэргэжлийн нийгэмлэг, холбооны тайлан, үйл ажиллагааны талаарх үнэлгээг жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор багтаан Зөвлөлд танилцуулан, зэргийн шалгалт зохион байгуулсан тухай нэгдсэн тайланг хэлэлцүүлэх;
- 3.1.5. Мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой санал, хүсэлт, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх;
- 3.1.6. Зэргийн шалгалтыг авсан мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбооны санал, дүгнэлтийг үндэслэн, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох тушаалын төслийг боловсруулан, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулах;
- 3.1.7. Мэргэшлийн зэрэг олгох шийдвэрийг үндэслэн мэргэшлийн зэргийн үнэмлэхийг батлагдсан загварын дагуу хэвлүүлэн бичиж, баталгаажуулан мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоонд хүргүүлэх
- 3.1.8. Мэргэшлийн зэргийн шалгалтын сорилын сангийн нууцлалыг хангах;
- 3.2. Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн чиг үүрэг:
- 3.2.1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл (цаашид “Мэргэжлийн салбар зөвлөл” гэх) нь дараах тохиолдолд зэргийн шалгалт авах үйл ажиллагааг зохион байгуулна:
- Тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн нийгэмлэг, холбоо байгуулагдаагүй;
 - Тухайн мэргэжлийн чиглэлээр энэхүү журмын 2.5 дахь шалгуур хангасан нийгэмлэг, холбоо байхгүй;
 - Тухайн мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь урьд онд зэргийн шалгалт явуулах эрх авсан ч зөрчил гаргаж, эрх нь хасагдсан тохиолдолд;
- 3.2.2. Мэргэшлийн зэрэг хамгаалахад шаардлагатай эмнэлгийн мэргэжилтний эзэмшвэл зохих тусгай шалгуурыг боловсруулж, Зөвлөлөөр баталгаажуулан мэргэжлийн нийгэмлэг, холбоонд хүргүүлэх;
- 3.2.3. Мэргэшлийн зэргийн онолын шалгалтын сорилын санг ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн түвшингийн ялгаатайгаар жил бүр шинэчлэн боловсруулж, баяжилтыг тогтмол хийх;
- 3.3. Мэргэжлийн нийгэмлэг, холбооны чиг үүрэг:
- 3.3.1. Мэргэшлийн зэрэг горилогчийн (цаашид “зэрэг горилогч” гэх) материалыг хүлээн авч, хянан, зэргийн шалгалтанд орох болзол хангасан болон хангагүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг албан тоотоор ажлын албанд хүргүүлэх,
- 3.3.2. Мэргэшлийн зэргийн шалгалтанд орох мэргэжилтэнд мэдээлэл, зөвлөгөө (унших материалын жагсаалт, жишиг сорил Г.М), давтлага өгөх;
- 3.3.3. Мэргэшлийн зэрэг хамгаалсан мэргэжилтний дүн болон хурлын тэмдэглэлийг ажлын албанд хүргүүлэх.

- 3.3.4. Мэргэшлийн зэрэг хамгаалсан мэргэжилтний дүнгийн хуудас, хурлын тэмдэглэлийг архивын хуулийн дагуу хадгалах;
- 3.3.5. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

3.4. Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг:

- 3.4.1. Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшлийн зэргийн шалгалтын талаарх мэдээллээр хангах;
- 3.4.2. Тухайн байгууллагаас мэргэшлийн зэргийн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтний материалыг хэлэлцэн, зэрэг горилогчийн материалыг мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлд хүргүүлэх;
- 3.4.3. Мэргэшлийн зэргийн шалгалтанд орж байгаа мэргэжилтэнд ажиллаж буй байгууллага нь ажлыг нь зохицуулах, дэмжлэг үзүүлэх;
- 3.4.4. Мэргэшлийн зэрэг авсан эмнэлгийн мэргэжилтэнд зэргийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоолоор тогтоосон хувь хэмжээгээр сар бүрийн үндсэн цалинд тооцож олгох;

4. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа

4.1. Мэргэшлийн зэрэг горилох мэргэжилтний бүрдүүлэх материал:

- 4.1.1. Мэргэшлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл;
- 4.1.2. Байгууллагын даргаар баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт. (Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулсан загвараар);
- 4.1.3. Нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулах баримтууд;
- 4.1.4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэшлийн диплом, мэргэшлийн үнэмлэхийн баталгаажсан хуулбар;
- 4.1.5. Мэргэшлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхийн эх хувь;
- 4.1.6. Иргэний үнэмлэхний хуулбар;
- 4.1.7. 3x4 хэмжээний зураг 2 хувь;

4.2. Эрүүл мэндийн байгууллага нь жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор мэргэшлийн зэрэг горилогч (цаашид “зэрэг горилогч” гэх)-ийн материалыг мэргэжлийн нийгэмлэг, холбоонд хүргүүлнэ.

4.3. Мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь зэрэг горилогчийн материалыг хянан үзэж зэргийн шалгалтанд орох болзол хангасан эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор ажлын албанда хүргүүлнэ.

4.4. Мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь жил бүр мэргэшлийн зэргийн шалгалтын тайлан, санхүүгийн нэгдсэн тайлан, санал, хүсэлтийг шалгалтын дараа 7 хоногийн дотор ажлын албанда ирүүлэх,

5. Мэргэшлийн зэргийн шалгалт

5.1. Мэргэжлийн шалгалт нь мэргэжлийн болон эрх зүйн чиглэлтэй байна.

5.2. Мэргэжлийн шалгалтыг онол болон дадлагаар авах бөгөөд онолын шалгалтанд 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд дадлагын шалгалтанд орно.

5.3. Онолын шалгалтыг сорилоор, дадлагын шалгалтыг гардан үйлдэл, практик бодлого, ярилцлагын хэлбэрээр авна. Онолын шалгалтын сорилын 20 хувь нь хууль эрх зүй, ёс зүйн асуулт байна.

5.4. Онолын шалгалтын дүнг шалгалт дууссанаас хойш 1 цагийн дотор шалгагч машинаар дүгнэн, дадлага шалгалтын дүнг шалгалтын дараа шууд мэдээлнэ.

5.5. Шалгалтын дүнгийн бодит байдлыг шалгалтын комисс хариуцна.

5.6. Зэрэг горилогч нь мэргэжлийн онолын болон дадлагын шалгалтанд тус бүр 85-аас дээш үнэлэгдсэн нөхцөлд тэнцсэнд тооцно.

6. Мэргэшлийн зэрэг хүчинтэй байх хугацаа, хүчингүй, нөхөн олгох

6.1. Тухайн мэргэжлээр ажиллаж байгаа бүхий л хугацаанд мэргэшлийн зэрэг хүчин төгөлдөр байна.

6.2. Эмнэлгийн мэргэжилтэн үндсэн мэргэшлийн сургалт ба төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамрагдан шинэ мэргэжлээр мэргэшсэн тохиолдолд мэргэшлийн зэрэг тухайн шинээр эзэмшсэн мэргэжилд хамаarahгүй.

6.3. Дараах тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хүчингүй болгох ба хугацаа нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон хугацаатай ижил байна:

- 6.3.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 26.3-т заасан шалтгаанаар;
- 6.3.2. Эрүүгийн хуулийн 101.1, 102.1, 104.2, 105.1, 106.1-д заасан шалтгаанаар;

6.4. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дараах тохиолдолд нөхөн олгож болно:

- 6.4.1. Гээгдүүлсэн, үрэгдүүлсэн;
- 6.4.2. Энэхүү журмын 6.3-д заасан үндэслэлээр хүчингүй болгосон хугацаа дууссан;

6.5. Мэргэшлийн зэргийн нөхөн олгуулахыг хүссэн эмнэлгийн мэргэжилтэн дараах материалыг бүрдүүлэн, ажлын албанад хүсэлт гаргана:

- 6.5.1. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл;
- 6.5.2. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт;

- 6.5.3. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг гээгдүүлсэн хэвлүүлэх бодит зардлын төлбөрийг ЭМХТ-ийн дансанд шилжүүлсэн төлбөрийн баримт;

6.6. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг нөхөн олгож буй тохиолдолд шалгалтанд орохгүй ба шинээр олгож буй үнэмлэхний баруун дээд хэсэгт “нөхөн олгов” гэж бичнэ.

7. Хариуцлага

7.1 Мэргэшлийн зэрэг олгох журмыг зөрчсөн үнэлгээний бодит байдалд шударга бус хандсан, ил тод бус, баталгаажилт бүрэн биш, тарифыг (эрүүл мэнд, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлагдсан) үндэслэлгүй өөрчилсөн тохиолдолд зэрэг олгосон нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааг Зөвлөлөөр хэлэлцэн зэргийн шалгалт зохион байгуулах эрхийг хасна.

7.2 Мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааны зөрчил гаргасан мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбооны шалгалтын дүнг хүчингүй болгож тухайн шалгалтыг зохион байгуулахад гарсан зардлыг тухайн мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоогоор төлүүлнэ.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх
ухааны сайдын 2013 оны 12 сарын 27-ны
өдрийн 197 тоот хамтарсан тушаалын
тавдугаар хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн
зэргийн үнэмлэхний загвар

Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн үнэмлэх нь дараах бичлэгтэй
байна.

1. Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн үнэмлэх нь 210мм х
297мм хэмжээтэй үнэт цаасан дээр, нууцлалтай, түмэн наст хээ бүхий цайвар
ягаан дэвсгэртэй, цэнхэр дэвсгэр дээр цагаан хас тэмдэг бүхий хүрээтэй, хүрээний
гадуур бараан ягаан өнгийн нууцлал бүхий хээтэй давхар хүрээтэй байна.
2. Мэргэшлийн зэргийн үнэмлэхний дээд талд “Эрүүл мэндийн яам”-ны
бэлгэдэл байна.
3. Мэргэшлийн зэргийн үнэмлэхийг Эрүүл мэндийн сайд гарын үсэг зурж
баталгаажуулна.
4. Мэргэшлийн зэргийн үнэмлэх нь дараах бичвэртэй байна.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ

0000001

Дугаар

..... овогтой -Д

Эрүүл мэндийн сайдын оны дугаар тушаалаар

..... мэргэжлээр

“.....” зэрэг олгов.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Эрүүл мэндийн сайд, Боловсрол
шинжилэх ухааны сайдын 2013 оны
12 сарын 27-ны өдрийн 491/1
тоот хамтарсан тушаалын
зургаадугаар хавсралт

МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

(Гаргацтай тодорхой бичиж бөглөнө үү!)

1. Эцэг/эхийн нэр Нэр

2. Нас

3. Хүйс эмэгтэй / эрэгтэй (зурна уу)

3x4
хэмжээний
зураг

4. Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--

5. Байгууллагын нэр

6. Одоогийн буй албан тушаал.....

7. Мэргэжил

8. Цахим шуудангийн хаяг.....

9. Гэрийн хаяг

10. Утас: Ажлын Гэрийн Гар утас

11. Шуудангийн хаяг _____

12. Цахим шуудангийн хаяг _____

Боловсрол, хөдөлмөр эрхлэлт

13. Төгссөн сургууль (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)

Сургууль	Орсон он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом/гэрчилгээний дугаар

14. Боловсролын зэрэг

Хаана	Огноо	Сэдэв	Боловсролын болон эрдмийн цол, зэрэг	Үнэмлэхний дугаар

15. Мэргэжлийн бэлтгэл

(Ажил, мэргэжил, бусад чиглэлээр суралцаж, мэргэшсэн байдлыг бичнэ)

Хаана	Эхэлсэн он, сар	Дууссан он сар	Мэргэшлийн чиглэл	Гэрчилгээ/сертификатын дугаар

16. Ажилласан туршлага

Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он

17. Одоо эзэмшиж буй мэргэшлийн зэрэг, түүнийг олгосон огноо, үнэмлэхний дугаар

18. Одоо горилж буй мэргэшлийн зэрэг

19. Ажил олгогчийн тодорхойлолт:

(Удирдлагын багаас хэлэлцэн дүгнэж, мэргэшлийн зэргийн шалгаруулалтад оруулахыг дэмжиж байгаа эсэхийг тодорхой бичнэ. Ёс зүй, хандлага, харилцааны хувьд дүгнэлт өгч тодорхойлно.)

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Материалын үнэн зөв болохыг шалгасан:

Хүний нөөцийн менежер.....

(гарын үсэг)

ДАРГА/ЗАХИРАЛ.....

(Байгууллагын дарга /захирал/-ын гарын үсэг, тамга)

онысарынөдөр

---000---



МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ КОМИССЫН ДҮНГИЙН ХУУДАС

Нэг. Анкетын хэсэг

1. Эцэг/эхийн нэр Нэр
- 2.
3. Нас
4. Хүйс эмэгтэй / эрэгтэй (зурна уу)

5. Регистрийн дугаар
6. Байгууллагын нэр
7. Одоогийн эрхэлж буй албан тушаал
8. Мэргэжил
9. Цахим шуудангийн хаяг.....

3x4
хэмжээний
зураг

Хоёр: Мэргэшлийн зэрэг олгох дүгнэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	Баталгаажилт
1.	Нийтлэг шалгуур хангасан байдал		
2.	Тусгай шалгуур хангасан байдал		
3.	Шалгалтын дадлага		
4.	ДҮН онол		
5.	Нийт үнэлгээ		

Дээрх үнэлгээний дүнг үндэслэн мэргэшлийн зэрэг горилогч
(эцэг/эхийн нэр) д/т
мэргэшлээр зэрэг ОЛГОХ / ОЛГОХГҮЙ БАЙХ
(зурна уу) саналтай байна.

Комиссын дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд

..... оны сарын өдөр

---000---